МЭДЭЭ · 2019 оны 12-р сарын 20


НИЙСЛЭЛИЙН 38 ДУГААР СУРГУУЛЬ ДЭЭР "ӨСВӨРИЙН ХУУЛЬЧИД" БАГ БАЙГУУЛАГДЖЭЭ



Баянгол дүүргийн прокурорын газар хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мөн сурагчдыг нийтээр дагаж мөрдөх эрх зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх дадал, хандлагатай болгох зорилгоор Нийслэлийн ерөнхий боловсролын 38 дугаар сургуультай хамтран "Өсвөрийн хуульчид" багийг бүрдүүлж, тодорхой ажлуудыг зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Энэхүү ажлын хүрээнд сурагчдын өвлийн амралт эхэлж байгаатай холбогдуулан хүүхдүүдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, цахим тоглоомын газарт хүүхдэд

ээлтэй эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх талаар захидал бичиж, тус дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа цахим тоглоомын газруудад хүргүүлжээ.



ЗАХИДАЛ

Сайн байна уу. Эрхэм танд энэ захидал очих өдрийн мэндийг Баянгол дүүргийн Прокурорын газар, Нийслэлийн ерөнхий боловсролын 38 дугаар сургуулийн харъяа "Өсвөрийн хуульч" багаас хүргэж байна. Бид эх орныхоо ирээдүй болсон хүүхэд багачуудаа төлөөлөн танд энэхүү захидлыг бичлээ.

Таны эрхлэн гүйцэтгэж буй үйл ажиллагаа нь хүүхэд багачууд бидэнд компьютер технологийн хөгжлийг таниулан сургаж, ирээдүйн хөгжилтэй хөл нийлүүлэн алхахад тусалж байгаа боловч бидний зарим найз нөхөд танай байгууллагаар үйлчлүүлэн компьютер тоглоом тоглон, интернет орчинд аялахдаа цагийг зүй зохистой баримтлахгүйгээр удаан хугацаагаар суух, интернет тоглоомонд донтох байдал цөөнгүй гарч байна.

Мөн зарим хүүхдүүд компьютер тоглоомонд донтсоны улмаас өөрийн эрүүл мэндээр хохирохоос гадна гэмт хэрэг, зөрчилд холбогдон ирээдүйн амьдралдаа хар толбо үлдээх явдал гарч байна. Иймд бид дараах саналуудыг хүргэж байна.


- Интернэт кафе, цахим тоглоомын үйлчилгээний газрууд нь хүүхдэд үйлчилгээ үзүүлэх таатай орчинг бүрдүүлэх;
- Цахим тоглоомын үйлчилгээг **9 насанд** хүрээгүй хүүхдэд үзүүлэхгүй ба 9-16 хүртэлх насны хүүхдэд зуны улиралд буюу 4 сарын 1-нээс 10 сарын 1-нийг хүртэлх хугацаанд **20.00** цаг, өвлийн улиралд буюу 10 сарын 1-нээс 4 сарын 1-нийг хүртэлх хугацаанд **18.00** цаг хүртэл үйлчлэх;
- Хүүхэдэд өдөрт нэг удаа 2 цагаас илүүгүй хугацаагаар үйлчилгээ үзүүлэхгүй байх;
- Насан хүрээгүй хүүхэд үйлчилгээ авч буй компьютерт хүүхэд үзэхийг хориглосон цахим хуудсыг нээдэггүй тохиргооны программыг заавал суулгасан байх.

Бидний энэхүү захидлаар хүргэсэн саналыг хүлээн авч өөрийн ажиллуулж буй газрыг хүүхдийн эрхийг хангасан, хамгаалсан тохилог сайхан орчинг бий болгосон танд баярлалаа.

Эх орны минь ирээдүй энх, амгалан байг.

Мөн гэр бүлийн орчинд хүүхдэд тавих хараа хяналтыг сайжруулах, хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд холбогдох болон өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар уриалга гаргаж эцэг эхчүүдэд хүргүүлсэн байна.





ЭЦЭГ ЭХЧҮҮДДЭЭ ХҮРГЭХ
ЗАХИДАЛ

Сайн байна уу. Эрхэм танд энэ захидал очих өдрийн мэндийг Баянгол дүүргийн Прокурорын газар, Нийслэлийн ерөнхий боловсролын 38 дугаар сургуулийн харъяа “Өсвөрийн хуульч” багаас хүргэж байна. Бид эх орныхоо ирээдүй болсон хүүхэд багачуудаа төлөөлөн танд энэхүү захидлыг бичлээ.

Эцэг эхчүүд та бүхнийг ажилдаа явсан үед таны хүүхэд хэнтэй үерхэж нөхөрлөн,чөлөөт цагаа хаана хэрхэн өнгөрүүлж байгааг анхаарч ярилцан, санаа тавьж байсан уу? хэмээн танаас асуумаар байна.

Бидний зарим найз нөхөд удаан хугацаагаар ухаалаг гар утас, компьютер тоглоом тоглон /ПС тоглоом/, интернет орчинд аялахдаа цагийг зүй зохисгүй ашиглаж байна. Үүнээс үүдэн тэд гэр бүлийн хараа хяналтаас гарч, компьютер тоглоом, ухаалаг гар утас зэрэгт донтож өөрийн эрүүл мэндээр хохирохоос гадна гэмт хэрэг, зөрчилд холбогдон ирээдүйн амьдралдаа хар толбо үлдээх асуудал гарч байна.

Таны энхрий бяцхан хүүхдийн тань хичээлийн жилийн 2 дугаар улирлын амралт 2019 оны 12 дугаар сарын 23-наас 2020 оны 01 дүгээр сарын 10-ныг дуустал үргэлжлэх билээ.

Иймд энэхүү амралтын хугацаанд эцэг эхчүүд та бүхэн үр хүүхдүүддээ тавих анхаарал халамжаа дээшлүүлэн, гэр бүлээрээ “ХУУЧИН ОН”-оо үдэн, “ШИНЭ ОН”-оо дурсамж дүүрэн угтаж, аз жаргалтай өдрүүдийг хамтдаа бүтээгээрэй.

Таны зөв хандлага
Таны хүүхдийн ирээдүй

2019.12.17

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2922